


853



**БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1990 оны *Асарын 27*

№ *318*

Улаанбаатар хот

**Зарим байгууллагын харьяаллын
тухай**

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Засгийн газрын 1990 оны 95 дугаар тогтоолоор Талх чихрийн үйлдвэрлэлийн нэгдэл татан буугдаж Талх чихрийн комбинат "Хүнсний үйлдвэр" нэгтгэлийн харьяанд шилжсэнтэй холбогдуулан хотын Талхны үйлдвэр, Чихэр боовны үйлдвэр, Хүнс тээврийн авто баазыг аж ахуйн тооцоотой бие даасан байгууллага болгон Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шууд харьяанд ажиллуулсугай.

2. Чихэр боовны үйлдвэр, Талхны үйлдвэр, Хүнс тээврийн авто баазын зохион байгуулалт, цалингийн сан, төлөвлөгөөг хянан зохицуулж өгөхийг хотын ХААХҮУ газар /н.Мижиддорж/, Нийгэм, эдийн засгийн хөгжлийн газар /н.Бат/, Санхүүгийн газар /н.Гонгор/-т үүрэг болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Signature]
Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

[Signature]
Ч.СУМААХҮҮ